



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/99

Өмнөдэлгэр сум

**Ойн сан бүхий газарт зорчихыг түр
хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.5, 18.2.12, 18.2.13, 18.2.14, 18.2.17 дахь заалт, Улсын онцгой комиссын “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2026 оны 01 дүгээр албан даалгавар, Хэнтий аймгийн Засаг даргын “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2026 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуурайшилтын төлөв байдал нэмэгдэж байгаа цаг агаарын байдлыг харгалзан 2026 оны 03 дугаар сарын 20-ноос 2026 оны 06 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд иргэдийг аялал зугаалга, амралт сувилалын зорилгоор ой, хээрийн бүсэд зорчих, ан, амьтан агнах, загас барих, ойн дагалт баялаг, байгалийн жамаар унасан бугын эвэр түүж бэлтгэх, иргэдийн ахуйн хэрэгцээ болон нөхөрлөлүүдийн ойн цэвэрлэгээний ажлаар мод бэлтгэх үйл ажиллагааг хориглосугай.

2.Ойгоос мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагааг зөвхөн ойн мэргэжлийн байгууллагуудтай түймрийн хариуцлагын гэрээг байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлсүгэй.

3.Эзэмшлийн ойн сангийн талбайд ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагууд харуул пост, хөдөлгөөнт эргүүл гарган машин техник, иргэдийн хөдөлгөөнд байнгын хяналт тавьж, ойгоо хамгаалах арга хэмжээ авч ажиллуулахыг ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагууд, Хэнтий шинэс сум дундын ойн анги болон байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

4.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг сайтар зохион байгуулж ажиллахыг Хэнтий шинэс сум дундын ойн анги, багийн Засаг дарга нар, байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Оюунгэрэл), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Т.Чинхуяг) нарт даалгасугай.



Р.ЭНХТӨР

2325310159